

“Сориг бумши”, “Жүдши” хоёр сурвалжаас эмийн Хот мандал болон зарим тоон утгуудыг харьцуулсан шинжлэлээр “Сориг бумши” эхэнд бичигдсэн болохыг тогтоосон нь

Далантай (Da leng tai)¹, Б.Болдсайхан¹, Ш.Болд¹, Жин Юн Ли (Jin yong li)², С.Ваанчигсүрэн³, С.Сээсрэгдорж¹

¹АШУУИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

²БНХАУ, ӨМӨЗО, ӨМҮИС, Харьяа эмнэлгийн хороо.

³АШУУИС, Анагаах Ухааны Сургууль

Цахим шуудан: dalantai1987@gmail.com, Утас: 89701987

Түлхүүр үг:

Сориг бумши, Жүдши, Сурвалж, Харьцуулалт, Уламжлал.

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны сурвалжуудыг харьцуулан шинжлэх нь анагаах ухааны үүсэл, хөгжил, уламжлал, дамжилт, түүхэн онцлогийг бодитой харуулах боломжтойн зэрэгцээ тухайн ард түмний анагаах ухаанд оруулсан хувь нэмэр тэр үеийн шашин-соёл, сэтгэлгээний уялдаа холбоог илтгэдэг цогц үр дүн болдогт үндэслэн судалгааг хийлээ. **Зорилго:** “Сориг Бумши”, “Жүдши” хоёр сурвалжийн “Язгуур үндэс”-ийн анхдугаар бүлэг”-т бичигдсэн “Эмийн хот мандал”-ын талаар бичсэнийг харьцуулж гаргалгаа хийх. **Арга, аргачлал:** Судалгааг “Сориг Бумши”, “Жүдши” сурвалжуудын төвөд эхийг эх хэрэглэгдэхүүн болгож, Эх бичиг сурвалж судлалын Сэдвээр бүлэглэх арга (theme analysis), Агууламжийн судалгаа (content analysis)-ны аргуудыг ашиглан хийлээ. **Үр дүн:** Хоёр сурвалжийн адил болон ялгаатай байдал нь Төвөдийн Бонбын ёсны ардын эмнэлэг үүсэж бүрэлдсэн уламжлал дээр үндэслэн Шаншүн оронд Бонбын ёсны “Сориг Бумши” эхлэн бичигдсэнийг их орчуулагч Бярузана Шаншүн хэлнээс орчуулж их Ютог Ёндонгомбо нар тэргүүлэн нэмж, хасаж засварлан, эмхэтгэн найруулж буддын мэдлэг ухааны онолд үндэслэсэн “Жүдши”-ийг бүтээсэн гэж үзэх нь нотолгоо бүхий байгааг дараах байдлаар тодруулан гаргалаа. **Дүгнэлт:** “Жүдши”-н эмийн хот мандлын зураглал нь үзвээс үзэсгэлэнт эмийн балгасыг төв болгоод дөрвөн зүгийн дөрвөн уулаар тодорхой дүрсэлж харуулсан нь өмнө бичигдсэн “Сориг Бумши”-ийн эмийн хот мандлыг хянан магадалж хасаж, нэмж засварлан цэгцэлж бичсэн болохыг илэрхийлж байна. Хоёр сурвалжид бичигдсэн тооны утга нь тухайн, тухайн үеийнхээ анагаах ухааны онолын сэтгэлгээний хоёр чиглэлийг илэрхийлж байгаагийн зэрэгцээ “Жүдши”-д анагаах ухааны өмнөх уламжлалыг өвлөн авахын зэрэгцээ бонгийн ёсны мэдлэг, ухааны уламжлалыг хасаж буддын мэдлэг ухааны онолд суурилж шалтгаан-үрийн шүтэн барилдлага ёсоор нэмэлт хийж өөриймшүүлсэн байна.

Үндэслэл: Түүхэн хөгжлийн явцад анагаах урлаг, оюунсэтгэлгээний өвүүд хэрхэн бүрэлдсэн хийгээд тэдгээрийн уламжлал, дамжилт, сэтгэлгээний онцлог, орчин ахуйгаа хэрхэн тусгасан талаар анагаах ухааны голлох эх сурвалжуудыг судлах нь жам ёсны байгаа юм.¹ Энэ ёсоор эртний Шаншүн орны бонбын анагаах ухааны түүхэн сурвалж “Сориг Бумши” болон Төвөдийн анагаах ухааны “Жүдши” сурвалжуудыг харьцуулан шинжлэх нь анагаах ухааны үүсэл, хөгжил, уламжлал, дамжилт, түүхэн онцлогийг бодитой харуулах

боломжтойн зэрэгцээ тухайн ард түмний анагаах ухаанд оруулсан хувь нэмрийг нотлоход үнэтэй хувь нэмэр болно.

Аливаа ард түмний уламжлалт анагаах ухаан өвчнийг эмчлэхийн зэрэгцээ тухайн үеийн байгаль-хүн, бие-сэтгэл, шашин-соёл, сэтгэлгээний уялдаа холбоог илтгэдэг цогц ойлголт болдог. Энэ агуулгаар хоёр сурвалжийг харьцуулан судлах зорилго болгосноо уламжлалт анагаах ухааны нийтлэг суурь үзэл, онол тэдгээрийн харилцан нөлөөлөл, уламжлалыг

таньж мэдэх ач холбогдолтой хэмээн үзэж байна. **Зорилго:** “Сориг Бумши”, “Жүдши” хоёр сурвалжийн “Язгуур үндэс”-ийн анхдугаар бүлэг”-т бичигдсэн “Эмийн хот мандал”-ын талаар бичсэнийг харьцуулж гаргалгаа хийх.

Зорилт:

1. Бонбын анагаах ухааны “Сориг Бумши”-ийн “Сэтгэлийн бум Хөх огторгуй”-н “Өгүүлэхийн шүтээний анхдугаар бүлэг” хийгээд “Жүдши”-ийн “Язгуур үндэс”-ийн “Өгүүлэхийн шүтээний анхдугаар бүлэг”-т “Эмийн хот мандал”-ын талаар бичсэнийг харьцуулан гаргалгаа хийх.

2. Бонбын анагаах ухааны “Сориг Бумши” болон “Жүдши”-д бичигдсэн зарим тооны утгыг харьцуулан гаргалгаа хийх.

Арга, аргачлал: Бонбын анагаах ухааны “Сориг Бумши” (gso rig 'bum bzhi) сурвалжийн Төвөд эх² болон “Жүдши” (rgyud bzhi) /төвөд хадмалт/-ийг эх хэрэглэгдэхүүн болгож, Эх бичиг сурвалж судлалын сэдвээр бүлэглэх арга (theme analysis), агууламжийн судалгаа (content analysis)-ны аргуудаар судалгааг хийлээ.^{3,4}

Үр дүн: Нэг. “Сориг Бумши”-д эмийн хот мандлыг эрхэм дээд Олмолинчин (འོ་མོ་གླང་ཆེན་ 'ol mo gling chen)-тэй холбон өргөн уудам орон зайд “Жүдши”-д эмийн хот мандлыг үзвээс үзэсгэлэнт хэмээх эмийн балгасын эргэн тойрон дахь цомхон хүрээллээр тодорхой дүрслэн харуулжээ. Хоёр сурвалжид бичигдсэн хот мандлын талаар нарийвчлан харьцуулбал:

А. “Сориг Бумши”-д эмийн хот мандлаа: Олмолинчин хэмээх ариун орныг загвар болгож түүндээ: 1.Олон давхар тивүүд, хүрээлэн буй ариун орчин. 2. Есөн давхар Юүндүн уул (གཡུང་རྒྱུང་དུང་གསལ་ g.yung drung bkod ra/) нь ариун барилга болох. 3. Хааны ордон, 8 тив - бурхны сургаал дэлгэрэх төвүүд. 4. 12 их тив, 12 бага тивүүд ба 16 их орон буюу шашны гэгээрлийн орон зай. 5. Бүрэн тойрсон далай, нуур, уул, гол мөрөн дэлгэр оршиж буйг өргөн хүрээнд авч үзээд энэ бүгд нь сүсэгтэн олны гэгээрлийн ариун орон болохыг дүрсэлжээ. Мөн “Нэвтлэгч” хэмээх нарны хүчин төгс аргын уул хүйтнийг анагаах, Цаст хэмээх сарны хүчин төгс билгийн уул халууныг анагаах элдэв эмийн ой цэцэрлэг болно хэмээн хоёр уулыг зааж өгүүлжээ.

В. “Жүдши”-д эмийн хот мандлаа: үзвээс үзэсгэлэнт эмийн балгасыг гол цөм болгоод Бонгийн ёсны хэсгүүдийг хасаад 1.Таван зүйлийн эрдэнээс бүтсэн эмийн ордон. 2. Өвчин анагаах, сэргээх-Эмийн ой цэцэрлэг. 3. Энэ ой цэцэрлэгийн Өмнө талын “Нэвтлэгч” ууланд халуун чанарын эм. Умар зүгийн “Цаст” ууланд сэрүүн чанарын эм байдаг тухай заасан Сориг бумшийн өмнөх уламжлал дээр арга билиг хосолсон Дорно зүгийн “Хүжсийн” үнэрт ууланд төрөл бүрийн эмийн ургамал болон арүрийг хэрхэн эмд хэрэглэж өвчнийг анагаах тухай, Өрнө зүгийн “Малаяа” ууланд бүх төрлийн өвчнийг анагаах эмүүд байдгаар хоёр уулыг нэмж тодорхой өгүүлжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Сурвалжуудад бичигдсэн “Эмийн хот мандал”-ын харьцуулалт

Үзүүлэлт	Сориг Бумшид	“Жүдши”-д засварласан нь
Хот мандлын орон зай нь	Өргөн уудам олон тив, уул, гол мөрөн.	Төв голд нь эмийн ордон түүнийг тойрсон эмийн 4 уул.
Үндсэн агуулга нь	Шашны гэгээрэл, бурхны сургаалын ариун орон болох	Эрүүл мэндийг хамгаалах, өвчнийг анагаах төв болох
Дүрслэлийн зураглал нь	Өргөн хүрээтэй Байгалийн зураглал	Өвчнийг оношлох, анагаах ордонтой холбоотой зураглал
Хот мандлын Зорилго нь	Бурхны гэгээн сургаалын орон болох	Бие, хэл, Сэтгэлийн тэнцвэрийг хадгалах эмийн орон болох

Хоёр. Хоёр сурвалжид 360 ба 404 гэсэн тоо хамгийн олон буюу “Сориг Бумши”-д 404 гэсэн тоо 12 удаа, 360 гэсэн тоо 13 удаа, “Жүдши”-д 404 гэсэн тоо 11 удаа, 360 гэсэн тоо 4 удаа давтагдаж бичигдсэн нь ижил төстэй байгаа боловч тооны агуулга нь ялгаатай, өөрийн онцлог бүхий мэдээллийг агуулж байна. Тухайлбал:

1. 360 тоог: “Сориг Бумши”-д “Еэшэн 360 (ཡེ་གཤེན་ ye gshen/ Бонбын шүтээн бурхад), Сайхар360 (གསལ་མཁར་ gsas mkhar/ Бонбын сүм), Лхариботон 360 (ལྷ་རི་ཤོ་མཚོན་ lha ri spo mthon/ тэргүүтэн 360-н Сүмбэр уул (སོག་རི་དབང་ sogs ri dbang /), Мүлэдондан 360 (མུ་ལོ་སྤང་ལྷན་ mu le stong ldan) тэргүүтэн 360 (མཚོ་སྤྱན་ mtsho sman/ Эмт

бодис гарах нуур ба далай), Юндүнзоншин (གཡུང་རྒྱུང་འཕྲོ་ཤིང་ g.yung drung ljon shing /) тэргүүтэн 360-н адил бус галбарваасан мод” гэсэн агуулгаар авч үзсэний зэрэгцээ эдгээрээс гарах эмийн түүхий эдийн төрөл зүйлд “чулуунаас гарах жонш, цала тэргүүтэн 360-н зүйл чулуун эм бүгд, шорооноос гарах барагшин тэргүүтэн 360-н зүйл шороон эм бүгд” гэсэн утгаар нарийвчлан бон ёсны шүтлэг, онгод, эмийн түүхий эдүүдийн харилцан шүтэлцээ бүхий илэрхийлсэн нь онцлог ялгаатай байна. Харин хоёр сурвалжид 360 тоог ангаах арга, хүний ясны тоо, судал, сэтгэлийг хорлогч ад гэж адил утгай авч үзжээ. Харин “Жүдши”-д судлын

тоог 368 гэж 8-р илүү нарийвчилжээ.

2. 404 гэсэн тоог: “Сориг Бумши”-д өвчин 404 зүйл боловч халуун ба хүйтэн хоёрт эс хуураагдах нь үгүй гэж заажээ. Харин “Жүдши”-д өвчний зүйл 404-ийг хий, шар, бадган, хурмал гэсэн дөрвөн үндсэн шалтгаантай холбоод даруйд анагаагдах 101, хотлоор нэрийдсэн адын 101, огоот бүтсэн насны өвчин 101, бусдын эрхт үйлийн үрийн өвчин 101 гэж нэмэлт хийж тодорхой заажээ.

Хэлцэмж: Бид эхлээд “Сориг бумши”-д бичигдсэн эмийн хот мандлын төв Олмолинчин (འོ་མོ་གླིང་ཤེན་ 'ol mo gling chen)-г анхаарах нь жам ёсны нотолгоо байх болно гэж үзлээ.

1. “Орчлонгийн нийт бүтэц” (འོ་མོ་གླིང་ཤེན་ srid pa spyi mdo/) хэмээх бон ёсны сударт: “Дээд хэсэг нь жаргалын орон, эрхэмсэг бөгөөд сэтгэл татам, дөрвөн их мөрний эх, уулын хаан Гандисийн бэлд, нуурын хаан Мапамюүцо (མ་ཕམ་གཡུ་མཚོ་ ma pham g.yu mtsho/)-гийн дэргэд, Оллун (འོ་ལུང་ 'ol lung) хэмээх ногоон оюу хот, ариун шидэт орон байна. Энэхүү хааны ордонд биеийн өнгө нь сар мэт гэрэлтсэн инээмсэглэлтэй, уул мэт сүр жавхлант биетэй, тод гялалзах хар үстэй, бүргэдийн өдөн нөмрөгтэй, өнгө өнгийн хормойтой, гэрэлт туяа цацруулсан Шинравмивочэ бурхан гартаа ариун хайрцгийг барьж сүр жавхлантай, эрхэмсэг, энэрэнгүй, нигүүлсэнгүйгээр оршино.” хэмээн дүрсэлж загвар болгосон.⁶

Мөн Бон ёсны “Нууц хураангуй судар” (མཛོ་འདུས་ mdo 'dus)-т Дагсигийн Олмолинчингийн талаар “Төв хэсэгт нь Юүндүнгийн Есөн Давхар Уул оршдог бөгөөд оргил нь мөнх цастай, цагаан гялалзсан сүрлэг харагддаг. Уулын ойролцоо Мапамюүцо нуур болон хүжийн үнэртэй уул байрладаг. Түүнчлэн, уг нутаг нь дөрвөн гол мөрний эх сурвалж болно. Эдгээр мөрнүүд тодорхой нэршилтэй бөгөөд Юүндүнгийн Есөн Давхар уулын дөрвөн талын амнаас урсдаг гэсэн загвараар харуулжээ.⁷

“Досэрмиг” (འོ་མོ་གླིང་ཤེན་) сударт: Ол (འོ་) - “Мөнх бусын эргэлтээс ангижрах”, Мо (མོ་) - “Хүсэл биелэх”, Лүн (ལུང་) - “Шинравмивочэгийн зөгнөл”, Рин (རིང་) - “Мөнхийн нигүүлсэл” гэсэн бэлгэдэл утгатай гэж тайлбарласан байна.⁸ Эндээс анхаарч үзвэл: **Агуулга нь:** Шинравмивочэгийн “мөнхийн нигүүлсэл” бүхий сургаалын гэрэл дор, энэхүү ертөнцөд төрөх ба үхэхийн үйлийн үрийн шаналал үгүй, хүсэн хүссэнээрээ мөнхийн жаргалыг эдлэх боломжтой байна. Ийнхүү Олмолунрин нь энгийн бодит ертөнц бус нийт олон хүрч чадахааргүй газарзүйн ойлголт ч бус харин Бон шашинтнуудын бясалгалын оргил, хамгийн төгс төгөлдөр сүнслэг ертөнц болон хувирсан тухай байгаа юм. Энэ нь Бон шашны онолын дээд тогтолцооны хураангуй томъёолол болжээ гэж үзэхээр байдаг.

Эндээс анхаарч үзвэл Олмолинчин нь газарзүйн болон бон шашны хоёр утгыг илэрхийлж байна. Үүнд: 1. Төвөдийн өндөрлөгийн тодорхой

түүхэн газарзүйн нэртэй холбоотой. 2. Бонбын шашин шүтэгчдийн бодиттой гэхдээ нууцлаг утгыг агуулж байна. Энэ нь Бон шашны судар бичгүүдээс үзэхэд Олмолинчинг Шаншүнгийн Олмолинчин болон Дагсигийн Олмолинчин гээд эхнийх нь газарзүйн төв, харин хоёр дахыг соёл иргэншлийн төв гэж үзэж байгаатай дүйж байна.⁵

Эдгээр судруудад бон ёсны АУ-ны үндэслэгч Шинравмивочийн тухай болон Юүндүн буюу хас сэтгэлгээний нууцлаг асуудал оршиж буй нь “Бон”-той холбоотой зайлшгүй анхаарах ёстой асуудлын нэг болох нь тодорхой байна.

Харин ногоон оюуны тухайд “Жүдши”-г зохиогч гэж үздэг Их Ютог Ёндонгомбын удмыг “Оюу дээвэрт” хэмээдэг нь голоор урсаж ирсэн оюуг гэрийнхээ дээвэр дээр тавьсантай холбож үзсэн байдаг. Харин Олмолинчингийн загварт Оллун (འོ་ལུང་ 'ol lung) хэмээх ногоон оюу хот, ариун шидэт орон гэж дүрсэлсэн байдгийг “Жүдши”-ийн зохиогч гэж үздэг Их Ютог Ёндонгомбыг алдаршуулах зорилго агуулж “Оюу дээвэрт” хэмээн тухайн нөхцөл байдалд тохируулан засварласан байж болохыг илэрхийлж байна.

Мөн хуучнаар ЗХУ-ын Ленинградын их сургуулийн эрдэмтэд Л.Н. Гумилев (L. N. Gumilev) болон Б.Л. Кузнецов (B. L. Kuznetsov, 1931–1985) нар “Олмолинчин бол хүмүүсийн төсөөлдөг шиг зүгээр л шашны хүслэнгийн хийсвэр ертөнц биш, харин ч Төвөд үндэстний эртний өвөг дээдэс нь Төв Ази дахь түүх, газарзүйн талаарх нийтлэг дурсамжаа энэхүү оюун санааны загварт нэгдсэн байдлаар тусгасан байх боломж маш өндөр” гэсэн дүгнэлтэд хүрснийг судлаачид хамгийн дэлгэрэнгүй гүн утга бүхий боломжит гаргалгаа гэж үзэж байна.¹⁰ Сүүлийн жилүүдэд Мюнхений их сургуулийн профессор Seibert Hummel Олмолинчингийн байршлын газрын зургийг шаншүн судлалынхаа гол бүтээл болох “Шаншүнгийн тухай тэмдэглэлүүд” (On Zhang zhung) номдоо оруулсан нь дээрх эрдэмтдийн дүгнэлтийг баталгаажуулжээ.⁵

Түүнчлэн Бон ёсны “Сориг Бумши” сурвалж Шаншүнгаддү буюу шаншүн хэлээр эхэлдгийг түүхэн сурвалжууд, археологийн судалгааны үр дүнгүүдтэй холбож үзвэл Шаншүн улс нь Төвөдийн хаант улс болон МЭӨ IV зуунаас ч өмнө өнөөгийн Төвөдийн баруун хэсэг Ари бүс нутагт хүчирхэгжин “Эртний Шаншүн соёл иргэншил”-ийг цогцлоосон болохыг судлаачид тогтоожээ.¹⁰ Шаншүнчууд өөрийн “Юүдүнгийн ариун бичиг” хэмээх бичиг үсэг зохиож хэрэглэж байсан нь бүрэн утсан ч Мар бичиг (མཎ་ཡིག་ smar yig) ба Лхава шонгад иг (ལམ་བཞོན་སྐད་ཡིག་ (lha ba gzhon skad yig) хэмээн нэрлэж байна. Гэхдээ Шаншүн бичгийн зарим эртний судрын хуучин эх бичмэлүүд хадгалагдан үлджээ. Бон шашны судруудад тэмдэглэснээр Шаншүн бичиг нь “Дагсиг” буюу Перс, өнөөгийн Иран зэрэг бүс нутгаас үүсэлтэй төдийгүй эртний Кашмир

болон Пунжабын (Punjab) бичигтэй холбоотой¹¹ гэж үздэг нь Дагсигийн Олмолинчинтой холбоо бүхий байгааг нотолдог. Өнөөгийн Төвөд бичиг Шаншүн бичгээс үлгэрлэсэн гэж судлаачид үзэж байна. МЭ VII зуунд Төвөдийн Соронзонгомбо хаан Шаншүнийг эзлэн мөхөөжээ.¹²

Бонгийн ёсны “Сориг Бумши”-ийн хот мандал нь өргөн уудам ариун орон зайг, “Жүдши”-ийн хот мандал нь нэг л эмийн балгасыг цөм болгоод тойрсон 4-н уулыг тодорхой дүрслэн харуулжээ. Эндээс анхаарч үзвэл Бонгийн ёсны “Сориг Бумши”-д хот мандлаа гол, мөрөн, уул, өргөн олон тивүүд байгаагаар дүрсэлсэн нь газар лусын эзэдтэй холбоотой байх магадлалтайн зэрэгцээ арга, билгийн онолыг үндэслэн хоёр уулыг авч үзсэн нь тус сурвалж эрт үед эхэлж бичигдсэн болохыг илэрхийлж байна. Харин “Жүдши”-д хот мандлаа үзвээс үзэсгэлэнт эмийн балгасыг төв болгоод дөрвөн зүгийн дөрвөн уулаар тодорхой дүрсэлж харуулсан нь өмнө бичигдсэн “Сориг Бумши”-ийн хот мандлыг хянан магадалж засварлан хасаж, нэмж өөрийн загварт оруулж оновчтой болгож бичсэний илэрхийлэл болж байна.

2. Хоёр сурвалжид бичигдсэн тооны утгаас анхаарвал “Сориг Бумши”-д бичигдсэн Бонбын шүтээн бурхад, Бонбын сүм, 360-н Сүмбэр уул, 360-н эмт бодис гарах нуур ба далай, 360-н адил бус галбарваасан мод” зэрэг Бонбын шашны онол номлол, байгалийн онгод, эзэдтэй холбоотой хэсгийг хассан нь тодорхой байна. Харин “Жүдши”-д буддын мэдлэг ухааны онолд суурилж шалтгаан-үрийн шүтэн барилдлага ёсоор нэмэлт хийж баяжуулж бичжээ. Энэ нь Л.Н. Гумилев (L. N. Gumilev) болон Б.Л. Кузнецов (B. L. Kuznetsov) нарын “Олмолинчин Төвөд үндэстний эртний өвөг дээдэс нь Төв Ази дахь түүх, газарзүйн талаарх нийтлэг дурсамжаа энэхүү оюун санааны загварт нэгдсэн байдлаар тусгасан”⁹ гэсэн бон шашны загварыг тасалж мартагнуулах бодлого барьж өөриймшүүлсэн болохын нэг нотолгоо юм.

Мөн энд анагаах ухааны бонгийн болон буддын онол номлолын хоёр чиглэлийг илэрхийлж байна. Энэ нь Германы эмч Рейн “Бүх анагаах ухааныг бурхан тэнгэрээс гаралтай гэж үзэлгүйгээр оршин тогтнож цэцэглэн хөгжсөн хэмээвэл амьдралд бүтэшгүй бөгөөд соёлыг шашнаас салган авч үзэх нь хүндэтгэлгүй хэрэг” хэмээн шашин, шинжлэх ухааныг хэт туйлшруулах үзлийг шүүмжилж уламжлагдан шинэчлэгдэх хандлагыг тодорхойлсон байдгийн нотолгоо болж байна.¹³

Эдгээр харьцуулсан шинжлэлд илэрч буй үр дүнгээс анхаарч үзвэл Бон ёсны “Сориг бумши” сурвалж нь Таримын нутаг дэвсгэр болох Шаншүнд Бонбын шашин хөгжин дэлгэрэх үедээ Дүд Бон (བདུན་དོན་ bdud dpon), Га Бон (ཀ་དོན་ ka dpon), Дүг Бон (འདུག་དོན་ drug dpon) гэсэн гурван аймагт

хуваагдаж, Хар Бон, Цагаан Бон гэсэн хоёр салбар чиглэлтэй байсантай холбогдож байна.¹⁰

Түүнчлэн өнөөгийн Төвөдийн анагаах ухааны судлаач нар Шинравмивочэгийн эм заслыг үзүүлсэн ёсыг Шаншүнд эм засал дэлгэрсэн түүхтэй холбож байгаагийн зэрэгцээ түүний хүү Жадбүтэшэй Аршийг Төвөдөд анагаах ухаан анхлан дэлгэрүүлэгчдийн нэрийн эхэнд зүй ёсоор бичдэг болсон нь Олмолинчингийн загвар түүний түүхэн уламжлалтай холбоотой байна.

Тухайн үеийн Таримын нутаг дэвсгэрт багтах Шаншүнд анагаах ухаан хир хүчтэй дэлгэрч хөгжсөнийг АШУ-ны доктор, профессор Б.Болдсайхан Шаншүнгаас Загарбадийн хаан тэргүүтэн Бонбын эм хийгээд “Танег” Шилба-рагмаан бүлэг зуундөрөвт: Бярузана Бонбыг Төвөд номд нийлүүлж орчуулсан гэж үзсэн¹⁴ нь Бярузана шороог, эмд нийлүүлж орчуулав, Бярузана судрыг, тарнид нийлүүлж орчуулав, Тарнийн орчуулга дотор Бярузана хэмээн бичив, Бонбын орчуулга дотор Ганшигтанда гэж бичив, Судар, ном, таалал, тайлбар сэлтийн их төлөвийг төвөд хэлэнд орчуулав¹⁷ хэмээсэн нь Шаншүн хэлнээс тухайн үеийн төвөд хэлээр ихэнхийг орчуулсан болохыг илэрхийлж байна. Түүгээр үл барам “Жүдши”-ийн доторх лидэр, дарьяаган, мончара, барүра зэрэг олон нэр, томьёо Шаншүн хэлээр бичигдсэн нь тэр хэвээрээ орчуулагдсан гэж үздэг.¹⁶

Энэ нь Ютогийн намтартай холбоотой “Гаржаам”-д Энэтхэгийн эмчийн асуултын хариуд: Ютог Шаншүнгийн ёсонд өвчнийг уруу суулгаж туулгах “жүд” /үргэлжлэл/, Юүндүн Бонбийн ёсонд: Өвчнийг амарлиулахад утах, хөхүүлэх, түрхэх гурван “жүд” уламжлан дамжсан тухай болон хуучин Ютог Ёндонгомбо Дүгү орны эмчийн асуултын хариуд: Шаншүнд хаан Юүндүнбалын үед эмч Зинарай анагаах үндсийг авсан хэмээн хариулсан нь Бонбын ёсны Шаншүн орны эм хийгээд бонгийн анагаах ухааны үүтгэл уламжлал дээр суурилан Шинравмивочэйн эхэлж хөгжүүлсэн бонгийн мэдлэг ухаан цэгцэрч хөгжсөн Юүндүн Бонбын эм заслыг таалснаа илэрхийлсэн сурвалжийн мэдээ баримтаар нотлогдог.¹⁴

Эндээс бага зэрэг гаргалгаа хийж үзвэл тухайн үеийн Таримын нутаг дэвсгэрт багтах Шаншүнд Их нууц тарнийн ухаан бусад мэдлэг ухааны онол номлолын үндэс суурь болж Грек, Персийн анагаах ухааны эм заслаас улбаатай Төвөдийн Бонбын ёсны ардын эмнэлэг үүсэж бүрэлдсэн уламжлал дээр нэмэгдэн Шаншүн орон нь анагаах ухааны их Аршийн орон болсон Таксил болон Кашмиртэй хил залгаа байсан нь Төвөдөд эртний Энэтхэгийн “Аюурвед” анагаах ухаан дамжих хамгийн таатай орчин болж байсанд үндэслэн¹³ Бонбын ёсны анагаах ухааны тэргүүлэх мэргэдийн нэг Шинравмивочэгийн эхлэн боловсруулсан уламжлалд тулгуурлан түүний хүү арш Жадбүтишэй нар тэргүүлэн анхлан

A Comparative Textual Analysis of the Medicinal Mandala and Numerical Concepts in the Sources “Sorig Bumshi” and “Gyudshi”: Establishing the Primacy of Sorig Bumshi

Da leng tai¹, Boldsaikhan B¹, Bold Sh¹, Jin yong li², Vaanchigsuren S³, Seesregdorj S¹

¹International School of Mongolian Medicine, MNUMS

²China. Inner Mongolia. Affiliated Hospital of National University for Nationalities

³School of Medicine, MNUMS

E-mail: dalantai1987@gmail.com, Tel: +976-89701987

Keywords:

Sorig Bumshi, Gyudshi, Source Criticism, Comparative Study, Traditional Knowledge Transmission

Abstract:

Background: A comparative study of classical medical texts within Traditional Medicine provides a vital framework for uncovering the origins, development, transmission, and historical significance of healing traditions. This approach highlights a specific culture’s contribution to medical knowledge and reflects the intricate interplay of religion, culture, and philosophical thought embedded in those eras.

Aim: To conduct a comparative analysis of the depictions of the “Medicinal Mandala” as described in the first chapter of the “Root Tantra” section in the two classical medical sources *Sorig Bumshi* and *Gyudshi*.

Materials and Methods: This research examines two foundational Tibetan medical texts—*Sorig Bumshi* and *Gyudshi*—using theme-based classification and content analysis methodologies grounded in textual source criticism.

Results: The findings confirm that *Sorig Bumshi*, a Bönpo medical text from the ancient Zhangzhung civilization, was composed earlier. The great translator Byaruzana translated it from the Zhangzhung language, after which Yuthok Yönten Gönpö and collaborators edited, revised, and systematized the text to form *Gyudshi*, embedding it in Buddhist epistemological frameworks.

Conclusions:

1. The medicinal mandala of *Gyudshi*—structured around a central “beautiful medicinal city” surrounded by four directional mountains—demonstrates a refined adaptation of the more expansive, sacred mandala depicted in *Sorig Bumshi*, which is centered on Olmo Lung Ring, a Bönpo pure land rich in symbolic geography.
2. The numerical values recorded in both texts—particularly the recurring use of 360 and 404—suggest different paradigms in medical theory. *Sorig Bumshi* embeds these numbers within a Bön cosmological and ritual context (e.g., 360 deities, mountains, and healing lakes), while *Gyudshi* reinterprets them under Buddhist causal reasoning (e.g., 404 diseases derived from wind, bile, phlegm, and karma). This transformation reflects a shift from Bön to Buddhist medical epistemology through selective integration and doctrinal refinement.